

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ—ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2025 онд нийт 273 арга хэмжээг тусган баталсны жилийн хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, Үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу байгууллагын үйл ажиллагааг дүгнэх аргачлалаар үнэллээ.

Хоёр. Үнэлгээний дүн

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 273 арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж “95.7” хувьтай байна. Хяналт—шинжилгээ, үнэлгээний дүнг үнэлгээ тус бүрээр үзүүлбэл дараах байдалтай байна.

- Бүрэн хэрэгжиж 100 хувиар үнэлэгдсэн 232 арга хэмжээ,
- Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж 90 хувиар үнэлэгдсэн 9 арга хэмжээ,
- тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70—80 хувиар үнэлэгдсэн 24 арга хэмжээ,
- тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50—60 хувиар үнэлэгдсэн 6 арга хэмжээ
- тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 40-30 хувиар үнэлэгдсэн 2 арга хэмжээ
- тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг 0 хувиар үнэлэгдсэн арга хэмжээ байхгүй байна.

Гурав. Төлөвлөлтөд хийсэн шинжилгээ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-аар баталсан загварын дагуу боловсруулан байна. Бодлогын баримт бичигт туссан зорилтод 108 арга хэмжээ, Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтод 43 арга хэмжээ, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтод 58 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтод 64 арга хэмжээг төлөвлөжээ.

Дараах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тухайн байгууллагыг хэрэгжүүлэхээр заасан зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт, суурь, хүрэх түвшний хамт тусгагдсан.

- Алсын хараа—2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө

Дөрөв. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилт

Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дагуу хяналт—шинжилгээ, үнэлгээг дараах 4 үндсэн чиглэлээр хийв.

- Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрсэн үр дүн
- Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт
- Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт—шинжилгээ, үнэлгээний үр дүн

Д/д	Хэсэг, дэд хэсэг	Гүйцэтгэлийн үнэлгээ	Дундаж хувь
	Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрсэн үр дүн		
1	Стратегийн 20 зорилго, 38 зорилт	нийт 108 арга хэмжээ 100%—94 90%—5 80%—4 70%—3 50%—1 30%—1	96.7%
	Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт арга хэмжээний хүрсэн үр дүн		
2	Стратегийн 10 зорилго, 17 зорилт	нийт 43 арга хэмжээ 100%—31 90%—2 80%—2 70%—5 60%—1 50%—2	91.9%
	Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт арга хэмжээний хүрсэн үр дүн		
3	Стратегийн 4 зорилго, 19 зорилт	нийт 58 арга хэмжээ 100%—53 90%—1	97.6%

		80%—1 70%—2 40%—1	
4	Дөрөв.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хүрсэн үр дүн		
	Стратегийн 12 зорилго, 18 зорилт	Нийт 64 арга хэмжээ 100%—54 90%—1 80%—3 70%—4 50%—2	95.6%
	Нийт 92 зорилт 273 арга хэмжээ	100%—232 90%—9 80%—10 70%—14 60%—1 50%—5 40%—1 30%—1	95,7%

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нийт 92 зорилтын хүрээнд 273 арга хэмжээний хэрэгжилт 95.7 буюу "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн). Хангалтгүй хэрэгжсэн 8 арга хэмжээ нь Төрийн худалдан авах ажиллагааны дагуу олон нийтэд нээлттэй тендер зарласан боловч материал ирүүлээгүй, хангалтгүй материал ирүүлсэн, гүйцэтгэгч татгалзсан, Улсын төсөвт санхүүжилт суугдаагүй зэрэг шалтгаанаас дээрх арга хэмжээнүүд 2025 онд бүрэн хэрэгжих боломжгүй болсон байна.

Тав. Дүгнэлт

1. Төлөвлөлт хийхдээ арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв санхүүгийн эх үүсвэр тодорхой байх, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц /SMART/ байх, судалгаа, шинжилгээнд суурилсан байх, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангасан байх, тоон мэдээлэл нь чанарын үзүүлэлтээр баталгаажсан байх гэсэн нийтлэг шаардлагыг хангаж ажиллаагүй.
2. Нэг ажил үйлчилгээ, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтааж тайлагнана. Тайлагнахдаа дараах асуудлыг заавал тусгасан байна. Тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг тодорхой дурдах гэсэн тусгай шаардлагыг хангаагүй тайлагнасан нь нь үр дүнг үнэлэхэд зөрүүтэй байдал үүсгэсэн.

Тулгамдаж буй асуудал

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан бүрэн хэрэгжээгүй 8 арга хэмжээ нь 2025 оны 12 дугаар 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар Албан даалгавар

гарсантай холбоотой 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон. Мөн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр саналаа хүргүүлсэн боловч Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны батлагдсан төлөвлөгөөнд тус 17 арга хэмжээ тусгагдаагүй байна.

Зургаа. Зөвлөмж

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх санал болон хяналт-шинжилгээ, үнэлгээнээс өгөх зөвлөмж:

1. Төлөвлөлт хийхдээ зорилтоо хангахуйц шалгуур зорилт түвшнийг суурь түвшинтэй харьцуулж зөв оновчтой тодорхойлох;
2. Судалгаа, хяналт шинжилгээний дүгнэлт зөвлөмжийг анхаарч үзэх, зорилтоо үр дүнд суурилсан байдлаар тодорхойлох;
3. Гүйцэтгэлийн тайланг ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу тайлагнахдаа иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, тодорхой, товч байх, тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, хэрэв үгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг тодорхой дурдах, нэг ажил үйлчилгээ, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах;

ТАНИЛЦСАН
ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

ХЯНАЛТ–ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ–ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Э.ОТГОНЦЭЦЭГ

Тайлангийн бүрдэл

(Хэрэгжилтийн тайланд энэ мэдээлэл зорилт тус бүрээр байх бөгөөд өөрийн үнэлгээ хийж хэрэгжээгүй арга хэмжээний шалтгаан нөхцөлийг бичсэн байна.)

Д/д	Зорилтын дугаар	Хэрэгжилт								Зорилтын хэрэгжилтийн хувь
		100%	90%	80%	70%	60%	50%	40%	30%	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ										
1.	1.1.1	1			1				1	66.6% зорилтот түвшинд хүрээгүй
2.	1.1.2	2			2		1			78% зорилтот түвшинд хүрээгүй
3.	1.1.3	1	1		1		1			77,5% зорилтот түвшинд хүрээгүй
4.	1.2.1	2	1	1						92,5% тодорхой үр дүнд хүрсэн
5.	1.2.2	2	1		2	1				81,7% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
6.	1.2.3	3	1							97,5% тодорхой үр дүнд хүрсэн
7.	1.4.1	1								Бүрэн хэрэгжсэн
8.	1.4.2	2	1		2					86% тодорхой үр дүнд хүрсэн
9.	1.4.3	1								Бүрэн хэрэгжсэн
10.	1.4.4	1	1							95% тодорхой үр дүнд хүрсэн
11.	1.4.5	2	1				1			85% тодорхой үр дүнд хүрсэн
12.	1.4.6	1	1		1					86,7% тодорхой үр дүнд хүрсэн
13.	1.4.7	2								Бүрэн хэрэгжсэн
14.	1.5.1	2								Бүрэн хэрэгжсэн
15.	1.5.2	1	1		1					86,7% тодорхой үр дүнд хүрсэн
16.	1.6.1	2					1			83,3% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
17.	1.7.1	2	1				1			85% тодорхой үр дүнд хүрсэн
18.	1.7.2	2			3					82% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
19.	1.8.1	1	1		1					86,7% тодорхой үр дүнд хүрсэн
20.	1.9.1	1					1			80% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
21.	1.10.1	2	1							96,7 тодорхой үр дүнд хүрсэн
22.	1.11.1	1	1		1	1				80% зорилтот түвшиндээ бүрэн

									хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
23.	1.12.1	1			1				85% тодорхой үр дүнд хүрсэн
24.	1.12.2	1							Бүрэн хэрэгжсэн
25.	1.12.3	2	1				1		85% тодорхой үр дүнд хүрсэн
26.	1.12.4	1			1				85% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
27.	1.13.1	3	1		1				92% тодорхой үр дүнд хүрсэн
28.	1.13.2	1	1		4	1			75,7% зорилтот түвшинд хүрээгүй
29.	1.13.3	2							Бүрэн хэрэгжсэн
30.	1.14.1	1	1		1				86.6% тодорхой үр дүнд хүрсэн
31.	1.14.2	3							Бүрэн хэрэгжсэн
32.	1.15.1	2	1		1	1			84% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
33.	1.16.1	2	2		3				84,3% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
34.	1.17.1	2	1				1		85% тодорхой үр дүнд хүрсэн
35.	1.18.1	2	1		1				90% тодорхой үр дүнд хүрсэн
36.	1.19.1	2			1				90% тодорхой үр дүнд хүрсэн
37.	1.19.2	3	1		1				92% тодорхой үр дүнд хүрсэн
38.	1.20.1	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
ХОЁР.ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ									
39.	2.1.1	2							Бүрэн хэрэгжсэн
40.	2.1.2	3	2		2				88,6% тодорхой үр дүнд хүрсэн
41.	2.2.1	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
42.	2.2.2	1	1		1		1		77,5% зорилтот түвшинд хүрээгүй
43.	2.2.3	1	1		1				86,7% тодорхой үр дүнд хүрсэн
44.	2.3.1	1	1			1			83,3% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
45.	2.4.1	2					1		83,3% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
46.	2.5.1	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
47.	2.6.1	2			2				85% тодорхой үр дүнд хүрсэн

48.	2.6.2	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
49.	2.7.1	2			1				86,7% тодорхой үр дүнд хүрсэн
50.	2.8.1	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
51.	2.8.2	1	2						93% тодорхой үр дүнд хүрсэн
52.	2.9.1	3	1						97,5% тодорхой үр дүнд хүрсэн
53.	2.10.1	2	1		1				90% тодорхой үр дүнд хүрсэн
54.	2.11.1	1							Бүрэн хэрэгжсэн
55.	2.11.2	2	1		1				90% тодорхой үр дүнд хүрсэн
56.	2.11.3	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
57.	2.12.1	2			2				85% тодорхой үр дүнд хүрсэн
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ									
58.	3.1.1	2							Бүрэн хэрэгжсэн
59.	3.1.2	2							Бүрэн хэрэгжсэн
60.	3.1.3	1			1				85% тодорхой үр дүнд хүрсэн
61.	3.2.1	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
62.	3.3.1	1					1		75% Зорилтот түвшинд хүрээгүй
63.	3.4.1	3			1				92,5% тодорхой үр дүнд хүрсэн
64.	3.4.2	3							Бүрэн хэрэгжсэн
65.	3.5.1	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
66.	3.5.2	2			2		1		78% зорилтот түвшинд хүрээгүй
67.	3.6.1	2							Бүрэн хэрэгжсэн
68.	3.6.2	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
69.	3.7.1	2				1			86,7% тодорхой үр дүнд хүрсэн
70.	3.7.2	2	1		1				90% тодорхой үр дүнд хүрсэн
71.	3.7.3	2							Бүрэн хэрэгжсэн
72.	3.7.4	3	1						97,5 тодорхой үр дүнд хүрсэн
73.	3.7.5	2	1		2				86% тодорхой үр дүнд хүрсэн
74.	3.8.1	2							Бүрэн хэрэгжсэн
75.	3.9.1	1			1				85% тодорхой үр дүнд хүрсэн
76.	3.10.1	1							Бүрэн хэрэгжсэн
ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ									
77.	4.1.1	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
78.	4.2.2	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
79.	4.2.3	2	1		1				90% тодорхой үр дүнд хүрсэн
80.	4.2.4	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
81.	4.2.5	2	1		1		1		82% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн

82.	4.2.6	1	1		1		1		77,5% зорилтот түвшин хүрээгүй
83.	4.2.7	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
84.	4.2.8	3			1				92,5% тодорхой үр дүнд хүрсэн
85.	4.2.9	2							Бүрэн хэрэгжсэн
86.	4.2.10	1	1		1				86,7% тодорхой үр дүнд хүрсэн
87.	4.2.11	1	1		1				86,7% тодорхой үр дүнд хүрсэн
88.	4.2.12	3	1			1			88% тодорхой үр дүнд хүрсэн
89.	4.2.13	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
90.	4.2.14	2			1		1		80% зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн
91.	4.3.1	2	1						96,7% тодорхой үр дүнд хүрсэн
92.	4.4.1	1	1						95% тодорхой үр дүнд хүрсэн
93.	4.4.2	1			1				85% тодорхой үр дүнд хүрсэн
94.	4.4.3	3	1						97,5% тодорхой үр дүнд хүрсэн
95.	4.4.4	3							Бүрэн хэрэгжсэн

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах хүснэгт”-ээр баталсан загварын дагуу боловсруулан байна.

1. Албан хаагчдыг ажиллах нөхцөл, хангамжийг сайжруулах зорилтын хүрээнд 4 арга хэмжээ;
2. Албан хаагчдыг сургалтаар хөгжүүлэх зорилтын хүрээнд 55 арга хэмжээ;
3. Албан хаагчдыг ажлын байранд сонгон шалгаруулах зорилтын хүрээнд 4 арга хэмжээ;
4. Удирдах албан хаагчдын манлайллын чадварыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2 арга хэмжээ;
5. Албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд 14 арга хэмжээ;
6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрын хөгжүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээ;

Нийт 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг төлөвлөж төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувьтай байна.

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
81.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	55	44	Дотоод сургалт, хөгжлийн үйл ажиллагааны хүрээнд: Төрийн байгууллага болон

	байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнээс	Ажлын байран дахь сургалт	32	28	бусад чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалтын ажил ерөнхийдөө тогтвортой хэрэгжсэн байна. Нийт 55 удаагийн сургалт, семинар зохион байгуулахаар төлөвлөснөөс 44-ийг гүйцэтгэж, 80 хувийн биелэлттэй ажиллажээ. Үүнээс ажлын байран дахь сургалт 87.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол мэргэшүүлэх сургалтын биелэлт 50 хувьтай буюу төлөвлөсөн хэмжээнээс бага байна. Харин бусад төрлийн сургалтууд 100 хувь биелжээ. Сургалтад хамрагдсан албан хаагчдын давхардсан тоо 6,528-д хүрсэн нь зорилтот түвшний 76.8 хувийг эзэлж байгаа хэдий ч нийт албан хаагчдыг сургалтад хамруулах хувь 93-т хүрсэн нь үндсэн төлөвлөгөөгөө бүрэн хангасан үзүүлэлт боллоо. Гадаад сургалт, мэргэшүүлэх үйл ажиллагааны хүрээнд: Байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулах гадаад сургалтын үзүүлэлтүүд төлөвлөснөөс давуулан биелсэн дүр зураг харагдаж байна. Нийт 15 удаагийн гадаад сургалт төлөвлөснөөс 18-ыг зохион байгуулж, биелэлт 120 хувьд хүрчээ. Үүнийг гадаад сургалтад хамрагдсан хүний тоо 168.7 хувиар буюу бараг хоёр дахин нэмэгдсэн Тухайлбал, эмэгтэй албан хаагчдын оролцоо 2.1 дахин, гүйцэтгэх болон туслах албан тушаалтнуудын оролцоо 2.2 дахин өссөн нь хүний нөөцийг тэвш хүртээмжтэй хөгжүүлэх тал дээр ахиц гарсныг илтгэж байна. Гадаад сургалтад нийт албан хаагчдын 29 хувийг хамруулсан бодит үр дүн гарсан.	
			Мэргэшүүлэх сургалт	14	7		
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-		
			Бусад	9	9		
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	Давхардсан тоогоор 8,496	Давхардсан тоогоор 6,528		
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-		
			Эрэгтэй албан хаагч	-	-		
			Удирдах албан тушаалтан	-	-		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-		
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	93	93		
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	15	18		
			2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	16	27	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	8	17		
			Эрэгтэй албан хаагч	8	10		
			Удирдах албан тушаалтан	9	11		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	7	16		
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	-	29%		
		3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-

4.	Шилжилт хөдөлгөөн	4.1.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх)	-	8%	Нийт 3 албан хаагч байгууллагаас шилжин явж, 8 албан хаагч бусад байгууллагаас шилжин ирсэн. Эдгээр шилжилт хөдөлгөөн нь нийт 78 албан хаагчийн 25 хувиас даваагүй тул хүний нөөцийн тогтвортой байдал хангагдаж, шилжилт хөдөлгөөн төлөвлөсөн хэмжээнд зохион байгуулагдсан болно. 4 албан хаагч байгууллагаас дотор шилжин ажилласан, 5 албан хаагч салбартаа шилжин ажилласан. 4 албан хаагч байгууллагаас дотор шилжин ажилласан, 9 албан хаагч байгууллагаас гарсан. 5 албан хаагч салбартаа шилжин ажилласан. 3 албан хаагч бусад салбар руу шилжин ажилласан. 6 албан хаагч бусад төрийн албанаас гарсан.
		4.2	Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо	-		
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-		
			Эрэгтэй албан хаагч	-		
			Удирдах албан тушаалтан	-		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-		
		4.3	Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	-		Нийт 3 албан хаагч байгууллагаас шилжин явж, 8 албан хаагч бусад байгууллагаас шилжин ирсэн. Эдгээр шилжилт хөдөлгөөн нь нийт 78 албан хаагчийн 25 хувиас даваагүй тул хүний нөөцийн тогтвортой байдал хангагдаж, шилжилт хөдөлгөөн төлөвлөсөн хэмжээнд зохион байгуулагдсан болно. 4 албан хаагч байгууллагаас дотор шилжин ажилласан, 5 албан хаагч салбартаа шилжин ажилласан. 4 албан хаагч байгууллагаас дотор шилжин ажилласан, 5 албан хаагч салбартаа шилжин ажилласан. 3 албан хаагч бусад салбар руу шилжин ажилласан.
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-		
			Эрэгтэй албан хаагч	-		
			Удирдах албан тушаалтан	-		

			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан			
5.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь			2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/08 дугаар тушаалаар нийт төрийн захиргааны 79, төрийн үйлчилгээний 14 албан хаагчийн цалингийн санг шинэчлэн баталсан.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	25,000	35,000	2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/376 дугаар тушаалаар албан хаагчдад зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан нэг өдрийн хоол, унааны зардлыг 35,000 төгрөг болгон шинэчлэн баталсан.
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)			21 аймгийн ГХБХБГ-ын албан хаагчдаас ажлын байрны орчин нөхцөлийн талаар сэтгэл ханамж, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй судалгаагаар компьютер техник хэрэгслийн 18 хувь нь сүүлийн 3 жилд худалдан авч ашиглаж байгаа, 82 хувь нь ашиглалтын хугацаа дууссан шинэчлэх шаардлагатай гарсан. 2025 оныг "Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил" болгон зарласантай холбогдуулан иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх, төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор 238 сумын газрын даамлын 185 иж бүрэн компьютер, 26 сканнер, 30 принтерийг нийт 765.2 сая төгрөгөөр, 4 аймгийн Геодезийн хэмжилтийн багажийг 128.0 сая төгрөгөөр, 20 аймгийн 170 сумын газрын даамлын 130 архивын шүүгээ, 37 ширээ, 57 сандал нийт 157.0 сая төгрөгөөр тус тус бүрэн шинэчилсэн.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	2025	1	2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 2024/358 дугаартай "Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийх гэрээ"-г Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй байгуулж, нийт 12,120,000 төгрөгийн өртгөөр 93 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 2025 оны 01
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	93	100%	

						дүгээр сард бүрэн хамруулсан.
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	1,235,507,103	Албан хаагчдын нийгмийн асуудалд нийт 1,235,507,103 төгрөг зарцуулсан.

Нээлттэй мэдээллийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Самбар болон цахим хуудсанд байршуулсан.	100%
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Самбар болон цахим хуудсанд байршуулсан.	100%
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Шалгуураас хасаж тооцов.	-
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Шалгуураас хасаж тооцов.	-
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Дутуу байршуулсан	70
1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Мэдээллийн самбар, цахим хуудсанд тодорхой ойлгомжтой байршуулсан.	100%
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Бүрэн байршуулсан.	100%
1.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Мэдээллийн самбар болон Цахим хуудсанд байршуулсан.	80%
1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Цахим хуудас мэдээллийн самбарт байршуулсан.	100%
1.10.	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Иргэдэд цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг сурталчлах, хэрэглээнд нэвтрүүлэх тухай мэдээллийг тухай бүр байршуулдаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			93,8 %
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			

2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Цахим хуудсанд болон мэдээллийн самбарт сул орон тооны зарын мэдээлэл байршуулсан.	100%
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Цахим хуудсанд байршуулсан. /2023 он/	100%
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Цахим хуудсанд байршуулсан. /2021.02.04/	100%
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Цахим хуудсанд дутуу байршуулсан.	70%
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Цахим хуудсанд байршуулсан. /2023.05.19/	100%
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Цахим хуудсанд байршуулсан. /2023.02.04/	100%
Хэсгийн дундаж хувь:			95%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	https://shilendans.gov.mn/	100%
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	https://shilendans.gov.mn/	100%
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Санхүүгийн тайлан хяналт шалгалтын дүгнэлтийг байршуулсан.	100%
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Үйлчилгээний хөлсний мэдээллийг шинэчлэн байршуулсан.	100%
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	https://shilendans.gov.mn/	100%
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	https://shilendans.gov.mn/ .	100%
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	https://shilendans.gov.mn/	100%
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Шалгуураас хасаж тооцов.	-
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Санхүүгийн тайлан хяналт шалгалтын дүгнэлтийг байршуулсан.	100%
3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл,	https://shilendans.gov.mn/	100%

	шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан		
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	https://shilendans.gov.mn/	100%
3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	https://shilendans.gov.mn/	100%
3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Шалгуураас хасаж тооцов.	100%
3.14.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Шалгуураас хасаж тооцов.	100%
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад.	Шалгуураас хасаж тооцов.	100%
Хэсгийн дундаж хувь: 96,3			100%
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг бүрэн шинэчилж, ойлгомжтой байдлаар байрлуулсан.	100%
4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2.2.3-т заасны дагуу зөвшөөрөл олгох, сунгах үйл явцыг нээлттэй, ил тод, цахим хэлбэрээр хэрэгжүүлэх зорилгоор www.license.gazar.gov.mn цахим системийг ашиглан зөвшөөрөл олгож байна. Мөн мэдээллийг иргэд, олон нийт нээлттэй орж харах боломжтой.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			96,3%